



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 18 он 01 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар ХЭГ/
205

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Шатахууны нөөц, үнийн хэлбэлзлийн талаар Засгийн газраас баримталж байгаа бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр Танд хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТООС ЕРӨНХИЙ САЙД
У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАН ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

1. Монгол Улсын хэмжээнд ойрын өдрүүдэд шатахууны хомсдол бий болж, шатахуун түгээх станцуудад дараалал үүсэж, иргэдийн дунд үл ойлгогдох нөхцөл байдал бий болоод байна. Иймд манай улсад шатахууны нөөц яг ямар хэмжээтэй байгаа, хомсдол үүсэх бодитой шалтгаан бий эсэх талаар.

2018 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 39 хоног /112,830.61 тн/-ийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 60 /14,416.06 тн/, Аи-92 болон Аи-95 автобензин 41 /40,699.19 тн/, дизелийн түлш 38 /56,060.35 тн/, ТС-1 онгоцны түлш 18 хоног /1,655.0 тн/-ийн нөөцтэй байна.

Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 147 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний 2017 оны компанийн нөөцийг 81900 тонн буюу 30 хоногийн хэрэглээнээс доошгүй байхаар тогтоосны дагуу Ашигт малтмал, газрын тосны газар нь шатахууны импорт, худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан.

Мөн Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 297 дугаар тогтоолоор 2018 онд бүрдүүлэх компанийн нөөцийн хэмжээг 94700 тонн байхаар тогтоосон. Тогтоолын хавсралтаар батлагдсан компанийн нөөц бүрдүүлэх үүрэг бүхий 21 компанитай 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор гэрээ байгуулж, хэрэгжилтийн хангуулан ажиллаж байна.


Сүүлийн өдрүүдэд үүсээд байгаа асуудал нь шатахууны нөөцийн хомсдол бий болох нөхцөл байдал үүсэж эхлэх дохио болсон гэж үзэж байна. Учир нь дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт, автобензин, дизель түлшний онцгой албан татварын нэмэгдэл, төгрөгийн ханш ам.долларын эсрэг сул байгаа зэрэг үүсвэрээс хамаарч шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд 2017 оны сүүлийн саруудад алдагдал хүлээж эхэлсэн бөгөөд шатахууны үнийг зах зээлийн журмаар зохицуулалгүй ард иргэдэд ирэх өргөн хэрэглээний үнийн дарамт учрахаас сэргийлж, үнийг нэмэгдүүлэхгүй барьж байсантай холбоотой юм. Учир нь зах зээлээс хамааралтай үнийг нэмэгдүүлэхгүйгээр барих нь аж ахуйн нэгжүүдийг алдагдалд оруулан дараа саруудад худалдан авах шатахууны эргэлтийн хөрөнгө буурах, захиалгын хэмжээ багасад хүргэсэн нь шатахууны хомсдол үүсгэх нөхцөлийг бүрдүүлээд байсан болно.

Иймд Засгийн газар шуурхай ажиллаж, гадаад зах зээлээс хамааралтай шатахууны үнэ өсвөл ард иргэдэд ирэх үнийн дарамтыг бууруулах, инфляц болон эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах зорилгоор ОУВС-тай яриа хэлэлцээ хийж эхлэхээр болж, Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 26

дугаар тогтоолоор А-80, Аи-92 автобензиний онцгой албан татварын хэмжээг “тэг” болгон өөрчлөлт оруулаад байна. Өнөөдөр буюу 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн жижиглэнгийн борлуулалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа болно.


2. Шатахууны үнийн өөрчлөлт өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэд хэрхэн нөлөөлдөг талаарх судалгаа (Тухайлбал, литр тутамд 100 төгрөгөөр нэмэгдэхэд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ хэдэн төгрөгөөр нэмэгдэх талаар),

Дэлхийн түүхий эдийн зах зээлд ОХУ-ын УРАЛС нэр төрлийн газрын тосны үнэ ханш сүүлийн өсч байгаатай холбоотойгоор ОХУ-аас манай улсад нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнэ 2017 оны 3, 4 дүгээр улиралд аажмаар нэмэгдэж ирсэн.



2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар олон улсын зах зээлд Уралс төрлийн газрын тосны үнэ ханш 1 баррель нь 67,43 ам долларт хүрч байна.

Futures & Indexes	Last	Change	%Change	Last Updated
WTI Crude	66.27	+0.88	+1.33%	(13 minutes delay)
Brent Crude	70.48	+0.48	+0.68%	(15 minutes delay)
Mars US	65.21	+0.79	+1.23%	(6 hours delay)
Opec Basket	67.32	+0.43	+0.64%	(23 Jan)
Canadian Crude Index	39.07	+0.59	+0.00%	(3 hours delay)
DME Oman	67.70	+0.40	+0.59%	(9 hours delay)
Urals	67.43	+0.00	+0.00%	(24 Jan)
Mexican Basket	59.09	+0.82	+1.38%	(15 Jan)
Indian Basket	67.51	+3.62	+5.37%	(23 Jan)
Western Canadian Select	34.22	+0.60	+1.74%	(21 Jan)
Middle East Sour Crude	67.48	+0.82	+1.40%	(23 Jan)
Dubai	66.21	+0.54	+0.80%	(23 Jan)
Brent Weighted Average	69.72	+0.64	+1.22%	(23 Jan)
Louisiana Light	68.60	+0.71	+1.03%	(23 Jan)
Coastal Grade A	55.25	+1.25	+2.25%	(24 Jan)
Domestic Swt. @ Cushing	62.25	+1.25	+2.00%	(24 Jan)
Giddings	55.00	+1.25	+2.28%	(24 Jan)



Үндэсний Статистикийн хорооноос гаргасан 2017 оны жилийн эцсийн өргөн хэрэглээний барааны үнийн өөрчлөлтийн статистик тоо мэдээллээс авч үзвэл өнгөрсөн 2017 оны жилийн эцсийн байдлаар **А-80 бензиний жижиглэнгийн үнэ 2.1 хувиар, А-92 бензиний үнэ жижиглэнгийн үнэ 6.5 хувиар, дизель түлшний үнэ 4.9 хувиар** тус тус өссөн байна.

Өргөн хэрэглээний барааны үнийн ерөнхий индексийн тооцон гаргадаг барааны бүлгээр авч үзвэл тээврийн бүлгийн үнийн индекс 2017 оны байдлаар өнгөрсөн оны түвшнээс 10.4 хувиар, үүний дотор **тээврийн үйлчилгээний индекс 4.8 хувиар** өсчээ.

Хүснэгт. Өргөн хэрэглээний барааны үнийн өөрчлөлт, 2013-2017 онуудын байдлаар

БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛЭГ	Жин	2013	2014	2015	2016	2017
Хунсний бараа, ундаа, ус	29.3	13.3	8.4	-6.1	1.2	6.4
Согтууруулах ундаа, тамхи	3.2	13.4	10.3	1.4	2.7	3.7
Хувцас, бөс бараа, гутал	16.1	17.6	14.3	5.5	1.5	4.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	7.8	16.3	3.2	-0.9	7.4
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	18.2	11.5	5.1	1.4	5.5
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	13.2	9.1	4.1	5.7	9.3
Тээвэр	12.2	3.0	8.6	1.4	-0.8	10.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	-0.3	0.0	-0.8	0.1	-0.5
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	0.3	8.1	2.4	0.2	3.9
Боловсролын үйлчилгээ	4.7	27.2	16.8	23.1	2.5	5.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	17.8	8.6	4.4	1.2	3.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	17.2	11.8	5.1	3.1	7.9
Ерөнхий индекс	100.0	12.5	11.0	1.9	1.1	6.4

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо, 2017 оны жилийн эцсийн статистик мэдээ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар өргөн хэрэглээний автобензиний онцгой албан татварыг тэглэх, өндөр октантай автобензин болон дизель түлшний онцгой албан татварыг одоо мөрдөж байгаа түвшинд хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн.

Ийнхүү автобензиний онцгой албан татварыг тэглэсэнтэй холбоотойгоор цаашид бензиний жижиглэн худалдаалах үнэ ханшид ойрын хугацаанд өсөлт гарахгүй гэж үзэж байна. Дунд болон урт хугацаанд газрын тосны бүтээгдэхүүний үнэ ханш өсөх эсэх нь гагцхүү дэлхийн зах зээл дэх газрын тосны эрэлт, нийлүүлэлтээс хамаарах болно.

Хэрвээ Засгийн газраас онцгой албан татварыг тэглэх арга хэмжээг аваагүй, үүний улмаас бензин, шатахууны жижиглэн худалдаалах үнийг литр тутамд 100

төгрөгөөр нэмэгдүүлсэн гэж тооцож үзвэл 2018 оны жилийн эцсийн байдлаар өргөн хэрэглээний барааны үнийн индексийг 1.4 пунктээр нэмэгдүүлэх магадлалтай.

3. Алслагдсан бүс нутгийн иргэдийн амьдрах нөхцөл боломжийг сайжруулах, төвийн бүстэй ойролцоо болгох нь одоогийн үүсээд байгаа төвлөрөл, түүнээс үүдэлтэй агаар, хөрсний бохирдол зэрэг олон асуудлыг шийдвэрлэх, сэргийлэх гарц гэж үзэж байна. Тэр дундаа алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүс нутагтай ойролцоо хэмжээнд байлгах шаардлагатай. Үүнийг шийдвэрлэхэд ямар шийдэл, боломж байгаа талаар.

Дотоодод борлуулж буй автобензин, дизель түлшийн жижиглэн борлуулалтын нэгжийн үнэ буюу бүтээгдэхүүний өртөг нь шатахууны импортын үнэ, татварууд /НӨАТ, ГАТ, ОАТ, АДАТ/, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардал болон ашиг зэргийн нийлбэрээс бүрддэг.

ОХУ-ын “Роснефть” компанитай манай улсын импортлогч компаниуд 2014 оны 5 дугаар сард байгуулсан хамтран ажиллах урт хугацааны гэрээнд олон улсын биржийн үнэнд суурилсан томъёоллоор сар бүр шатахууны импортын үнийг тооцож байхаар тусган, худалдааны СРТ-Наушки, СРТ-Соловьевск (тээврийн зардлын нэмэгдэл 50 ам.доллар), СРТ-Абаза (тээврийн зардлын нэмэгдэл 60 ам.доллар) нөхцөлүүдээр худалдан авдаг ба Абаза-Улаангом тээврийн зардал тонн тутамдаа 90 ам.доллар байдаг. Энэ нь Сүхбаатар, Алтанбулаг боомтуудаар импортлох шатахууны импортын үнэ дээр баруун бүсэд 150 ам.доллар, зүүн бүсэд 50 ам.долларын тээврийн зардал нэмэгдэх юм. Мөн үйл ажиллагааны зардал болон агуулахаас шатахуун түгээх станц хүртэлх тээврийн зардлыг нэмэгдүүлэхэд төвийн бүсээр борлуулж байгаа жижиглэн борлуулалтын үнэтэй харьцаалахад бүтээгдэхүүний төрөл бүс нутгаас хамааран литр тутамд 100-190 орчим төгрөгийн зөрүүтэй байна.

Аймаг, хотын нэр	А-80 /литр/		АИ-92 /литр/		АИ-95 /литр/		ДТ /литр/	
	01 сарын 16	01 сарын 23	01 сарын 16	01 сарын 23	01 сарын 16	01 сарын 23	01 сарын 16	01 сарын 23
Баруун бүсийн дундаж үнэ	1,596	1,617	1,724	1,724	1,900	1,963	1,802	1,821
Хангайн бүсийн дундаж үнэ	1,534	1,534	1,676	1,676	1,916	1,916	1,777	1,777
Улаанбаатар хотын дундаж үнэ	1480	1480	1630	1643	1880	1990	1723	1733
Төвийн бүсийн дундаж үнэ	1,533	1,533	1,703	1,704	1,906	1,936	1,762	1,775
Зүүн бүсийн дундаж үнэ	1,601	1,587	1,730	1,717	1,913	1,940	1,837	1,857

Улсын дундаж үнэ	1,566	1,568	1,708	1,705	1,909	1,939	1,794	1,808
-------------------------	--------------	--------------	--------------	--------------	--------------	--------------	--------------	--------------

Хүснэгт 1: Шатахууны жижиглэн борлуулалтын дундаж үнэ бүсээр

Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогын хүрээнд гадаадын зах зээл дээрх газрын тосны үнэ болон дотоодын зах зээл дээрх валютын ханшийн хэлбэлзлийг харгалзан Онцгой албан татварын тухай хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газраас тогтоон татварын зохицуулалтыг тухай бүр хийж ирсэн.

Онцгой албан татварын зохицуулалтын талаар:

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн огцом бууралттай холбоотойгоор 2015 оны 11 дүгээр сараас алслагдсан бүс нутагт борлуулж буй шатахууны жижиглэн борлуулалтын үнийг төвийн бүсийн үнэтэй ижил түвшинд хүргэх зорилтын хүрээнд автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг бүс боомтоос хамааруулан Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 438 дугаар тогтоолоор ялгавартай тогтоосон.

Бүтээгдэхүүний төрөл /октаны хэмжээ/	Онцгой албан татварын хэмжээ			Тогтоол огноо, дугаар
	<i>Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг</i>	<i>Эрэнцав</i>	<i>Боршоо, Цагааннуур болон бусад боомтууд</i>	
2015 он 11 сар				
90 хүртэл	400,000 ₮/тн	270,000 ₮/тн	0 ₮/тн	Засгийн газрын 2015.11.09-ний өдрийн 438 дугаар тогтоол
90 болон түүнээс дээш	400,000 ₮/тн	270,000 ₮/тн	0 ₮/тн	
Дизель	520,000 ₮/тн	390,000 ₮/тн	0 ₮/тн	

Гэвч 2016 оны сүүлийн хагас жилээс эхлэн ам.доллартай харьцах төгрөгийн ханш эрс суларсан, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өссөнтэй холбоотойгоор газрын тосны бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн зардал өсч, жижиглэнгийн борлуулалтын үнэд өөрчлөлт оруулах нөхцөл үүсээд байсан тул Засгийн газраас жижиглэн борлуулалтын үнийг тогтворжуулах зорилгоор яаралтай арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 109 дүгээр тогтоол, 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 166 дугаар тогтоол, 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор онцгой албан татварын хувь хэмжээг 3 удаа бууруулсан. Үүний үр дүнд шатахууны жижиглэн борлуулалтын үнийн огцом өсөлтийг саармагжуулж чадсан билээ.

Бүтээгдэхүүний төрөл	Онцгой албан татвар			Тогтоол огноо, дугаар
	<i>Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг</i>	<i>Эрэнцав</i>	<i>Боршоо, Цагааннуур болон бусад боомтууд</i>	
<i>/октаны хэмжээ/</i>				
2016 он 10 сар				
<i>90 хүртэл</i>	260,000 ₮/тн	130,000 ₮/тн	0 ₮/тн	Засгийн газрын 2016.10.05-ны өдрийн 65 дугаар тогтоол
<i>90 болон түүнээс дээш</i>	260,000 ₮/тн	130,000 ₮/тн	0 ₮/тн	
<i>Дизель</i>	280,000 ₮/тн	150,000 ₮/тн	0 ₮/тн	
2016 он 11 сар				
<i>90 хүртэл</i>	160,000 ₮/тн	30,000 ₮/тн	0 ₮/тн	Засгийн газрын 2016.11.30-ны өдрийн 166 дугаар тогтоол
<i>90 болон түүнээс дээш</i>	160,000 ₮/тн	30,000 ₮/тн	0 ₮/тн	
<i>Дизель</i>	180,000 ₮/тн	50,000 ₮/тн	0 ₮/тн	
2017 он 1 сар				
<i>90 хүртэл</i>	50,000 ₮/тн	0 ₮/тн	0 ₮/тн	Засгийн газрын 2017.01.25-ны өдрийн 34 дүгээр тогтоол
<i>90 болон түүнээс дээш</i>	30,000 ₮/тн	0 ₮/тн	0 ₮/тн	
<i>Дизель</i>	70,000 ₮/тн	0 ₮/тн	0 ₮/тн	


Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2017 оны 7 дугаар сараас үе шаттайгаар нэмэгдүүлэхээр тохиролцсоны дагуу Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 207 дугаар, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор тус тус тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн.

Бүтээгдэхүүний төрөл	Онцгой албан татвар			Тогтоол огноо, дугаар
	<i>Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг</i>	<i>Эрэнцав</i>	<i>Боршоо, Цагааннуур болон бусад боомтууд</i>	
<i>/октаны хэмжээ/</i>				
2017 он 07 сар				
<i>90 хүртэл</i>	160,000 ₮/тн	30,000 ₮/тн	0 ₮/тн	Засгийн газрын 2017.07.18-ны өдрийн 207 дугаар тогтоол
<i>90 болон түүнээс дээш</i>	160,000 ₮/тн	30,000 ₮/тн	0 ₮/тн	
<i>Дизель</i>	180,000 ₮/тн	50,000 ₮/тн	0 ₮/тн	
2017 он 11 сар				
<i>90 хүртэл</i>	190,000 ₮/тн	60,000 ₮/тн	0 ₮/тн	Засгийн газрын 2017.11.15-ны өдрийн 309 дүгээр тогтоол
<i>90 болон түүнээс дээш</i>	210,000 ₮/тн	80,000 ₮/тн	0 ₮/тн	

Дизель	280,000 ₮/тн	150,000 ₮/тн	0 ₮/тн
---------------	--------------	--------------	--------

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ 2017 оны 07 дугаар сараас тогтмол өссөнтэй холбоотойгоор шатахууны импортын үнэ өссөн, төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсан, автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор шатахууны жижиглэн борлуулалтын үнэд өөрчлөлт оруулах нөхцөл, шаардлага үүссэн.

Тодруулбал, Сүхбаатар боомтоор импортлосон Аи-92 автобензиний импортын үнэ 2017 оны 7 дугаар сараас эхлэн тогтмол өссөөр 2018 оны 01 дүгээр сард тонн тутамд 668 ам.долларт хүрч 127 ам.доллар буюу 23.47 хувиар, дизель түлшний хувьд мөн адил 2017 оны 07 дугаар сараас эхлэн тогтмол өссөөр 2018 оны 01 дүгээр сард тонн тутамд 631 ам.долларт хүрч 156 ам.доллар буюу 32.84 хувиар тус тус өсөөд байна. Цаашид 2018 онд дэлхийн зах дээрх газрын тосны үнэ өсөх төлөвтэй байна.



Иймд Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор А-80, Аи-92 автобензиний онцгой албан татварын хэмжээг “тэг” болгон өөрчлөлт оруулж автобензинийн жижиглэн борлуулалтын үнэ, хангамжийг тогтвортой байлгах талаар шуурхай арга хэмжээ авсан.

Тээвэр ложистикийн зардлыг бууруулах зорилгоор 2015 онд Монгол, Хятадын зам тээврийн болон холбогдох байгууллагуудын хамтарсан ажлын баг Хөх хотын боловсруулах үйлдвэрээс Ганц мод-Гашуун сухайтын боомтоор Цогтцэций, Ханбогд хүртэл шатахуун тээвэрлэх замын маршрутыг судлан тээвэрлэлт хийх боломжтой тухай дүгнэлт гаргасан. Хятадын “Чайна Ойл” компани нь Хөх хотын нефть боловсруулах үйлдвэрээс Ганцмод-Гашуунсухайт боомтоор газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа талаар 2016 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний уулзалтын үеэр мэдэгдэж байсан боловч Тянжин боомтод гарсан ослын улмаас Хятадын талын холбогдох эрх бүхий байгууллагаас

Ганцмодны боомт дээр аюултай бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай гарах терминал байгуулах шаардлага тавьсантай холбоотойгоор тус ажил хойшлогдоод байна.

Мөн ОХУ-ын Ангарскийн газрын тос боловсруулах үйлдвэрээс шатахуун тээвэрлэхэд төмөр замаар Аббаза дахь агуулах хүртэл 1000 км, агуулахаас автоцистернээр Завхан аймгийн Баянтэс сум хүртэл 750 км байдаг тул Арцсуурь боомтоор шатахуун нийлүүлэхийн тулд нийт 1750 км замыг туулах шаардлагатай байдаг. Тээврийн зардал өндөр байдаг болон тээвэрлэлтийн явцад ОХУ-ын нутагт Зүүн тагнын өндөр давааг давах, Монголын нутагт өвлийн улиралд хамгийн хүйтэн байдаг газар Тэс голын хөндийг туулдаг тул дэд бүтэц, бүтээн байгуулалт хийгдсэнээр шатахуун импортлох боломж бүрдэх юм. Ханх боомтоор шатахуун импортлах мөн адил тээвэрлэлтийн зардал өндөр байгаагаас эдийн засгийн үр ашиг багатай гэдэг үндэслэлээр импортлогч компаниуд тээвэрлэлт хийхгүй байгаа болно.

Тээвэр ложистик, замын нөхцөлийг сайжруулах, боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, ОХУ болон БНХАУ-ын талтай яриа хэлэлцээ хийх зэрэг арга хэмжээнүүдийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлэх болно.

Иймд дээр дурьдсан үйл ажиллагаануудтай автобензин, дизель түлшний онцгой албан татварын зохицуулалтын бодлогыг уялдуулан алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогыг тухай бүр хэрэгжүүлэх болно.

4. Газрын тос боловсруулах үйлдвэр хэзээ ашиглалтад орж, нефтийн бүрэн хараат байдалд нэрвэгдэж буй энэ эрсдлээс хэрхэн сэргийлэх талаар Засгийн газар ямар бодлого баримталж, хэрэгжүүлж байна вэ? Газрын тосоо түүхийгээр нь гадагш нь зөөж, өөрсдөө өндөр үнэтэй шатахуун авдаг өнөөгийн гажуудлыг хэзээ хэрхэн засах вэ?

Үндэсний аюулгүй байдлын 2014 оны 14/06 тоот зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулж, Монгол Улсыг газрын тосны бүтээгдэхүүнээр хангах суурийг бий болгоход оршино. Төслийн хүрээнд жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулж евро стандартын шаардлага хангасан автобензин, дизель түлш, шингэрүүлсэн шатдаг хий болон бусад дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх бөгөөд тус боловсруулах үйлдвэрийг түүхий тос дамжуулах хоолойн хамт байгуулна.

Уг төслийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 59 дүгээр тогтоолоор Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд төслийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит компанийг Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Хоёр улсын Засгийн газар хооронд байгуулах зээлийн ерөнхий хэлэлцээрийг Улсын Их хурлаар 2017 оны 5 дугаар сард хэлэлцэн соёрхон баталсан.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит компани нь “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлж, Зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг 2017 оны 2 дугаар сараас 8 дугаар сарын хооронд Энэтхэг Улсын Эксим банктай хамтран зохион байгуулсан бөгөөд уг сонгон шалгаруулалтад БНЭУ-ын “Инженерс индиа лимитед” компани шалгарч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-тай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 8 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан. Яамны зүгээс нарийвчилсан ТЭЗҮ-ний ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд ТЭЗҮ-ийн эхлэлийн тайланг 2017 оны 11 дүгээр сард ирүүлээд байна. Энэхүү нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын Зөвлөх үйлчилгээний санхүүжилт хоёр улсын Зээлийн хэлэлцээрийн хүрээнд хийгдэж байгаа бөгөөд 2018 оны нэгдүгээр улиралд багтаан эцсийн тайланг хүлээн авахаар ажиллаж байна.

Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд Зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа компанийн туслан гүйцэтгэгчээр ажиллаж буй "Престиж Инженеринг" ХХК үйлдвэрийн байршил, дамжуулах хоолойн трассын төлөвлөлттэй холбоотой байрзүй, геодези, инженер-геологи, усны судалгааны ажлуудыг орон нутагт 2017 оны 11 дүгээр сараас эхлэн гүйцэтгэж байна.

Үйлдвэрээс гарах бэлэн бүтээгдэхүүнийг гол зах зээлд нийлүүлэх дэд бүтэц, газрын тосны ордуудын байршил, түүхий тос дамжуулах хоолой тавих газарзүйн байдал, улс орны хөгжлийн бодлого зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзэж боловсруулах үйлдвэрийг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулж, үйлдвэрийн газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэрийг Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар шийдвэрлэв.

Монгол Улсын газрын тосны нөөц, олборлолтын түвшин нь үйлдвэр байгуулах хэмжээнд очсон байгаагаас гадна жил бүр 1-1.2 сая тонн түүхий тосыг экспортолж байна. Олборлолтын хэмжээг 2020 он гэхэд 1.5 сая тонн болгож нэмэгдүүлж 2040 он хүртэл олборлолтыг энэ түвшинд барих төлөвлөгөөтэй байна. Иймд дотоодын түүхий эдийг түшиглэн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх Үндэсний хэмжээний боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 2018 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлж 2022 он гэхэд бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Монгол Улсын Газрын тосны тухай хуулийн 7.1.6 болон 11.2.4. дэх заалтуудын дагуу Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх гэж заасан болно.

5. Автобензин, дизель түлшний үнэ нэмэгдэж, түүнийг дагаад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, үндэсний томоохон баяр цагаан сарын өмнө үнэ ханш өсөж байгаа нь ард иргэдийн дунд бухимдал

үүсээд байна. Иймд автобензин, дизелийн түлшний үнэ нэмэгдэх бодит шалтгаан байгаа эсэх, үндэслэлтэйгээр үнэ нэмэгдэж байгаа бол шатахуун импортлогчидтой үр дүнтэй хамтран ажиллах, яаралтай хэлэлцээрт орох, гарц шийдэл олох, үндэслэлгүйгээр үнээ нэмж байгаа бол хариуцлага тооцох шаардлагатай гэж үзэж байна. Энэ бүхний эцэст иргэд хохирч болохгүйг хатуу санах хэрэгтэй талаар.

Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 207 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор тус тус автобензин, дизель түлшний онцгой албан татварыг үе шаттайгаар сэргээн тогтоосонтой зэрэгцэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ 2017 оны 7 дугаар сараас тогтмол өссөн, Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсан зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөр шатахууны жижиглэн борлуулалтын үнэд өөрчлөлт орох нөхцөл аажмаар бүрэлдэж эхэлсэн.

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх, шатахууны хангамж, үнийн асуудлаар Засгийн Газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл” тухай бүр хуралдаж, шатахууны хангамж, жижиглэн борлуулалтын үнийн тогтвортой байдлыг хангаж ажиллах зөвлөмжийг импортлогч компаниудад хүргүүлж ирсэн.

Гэвч дээр дурьдсан хүчин зүйлсийн нөлөөллөөр шатахууны жижиглэн борлуулалтын үнэд өөрчлөлт орох нөхцөл бүрэлдсэн талаар шатахууны импортлогч компаниуд удаа дараа мэдэгдсэн.

Уг асуудлыг Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанд хэлэлцэж, асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарыг боловсруулан ирүүлэхийг УУХҮ-ийн сайд болон Сангийн сайд нарт үүрэг болгосон.

Засгийн Газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн 2018 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн долдугаар хуралдаанаар шатахууны жижиглэнгийн үнийн бүрдэлт, компаниудын ашиг, алдагдлын тооцоог судлаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг гарч зөвлөлийн дараагийн хуралдаанаар танилцуулах зөвлөмжийг гаргасан.

Уг зөвлөмжийн дагуу Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 13 дугаар тушаалаар батлагдсан

“Шатахууны жижиглэнгийн үнийн бүрдэлт, компаниудын ашиг, алдагдлын тооцоог судлаж санал, дүгнэлт гаргах” үүрэг бүхий Ажлын хэсэг батлагдан, дүгнэлтийг Засгийн Газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, “Өргөн хэрэглээний А-80, Аи-92 автобензиний хангамж, үнийн тогтвортой байдлыг ханган ажиллах” зөвлөмжийг импортлогч компаниудад гаргасан байдаг.

Ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаас гарсан зөвлөмж, салбар хариуцсан байгууллагын мэдээлэлтэй танилцан Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар А-80, Аи-92 автобензиний онцгой албан татварын хэмжээг “тэг” болгон өөрчлөлт оруулж автобензинийн жижиглэн борлуулалтын үнийг тогтвортой барих арга хэмжээг авсан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**2013-2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ШАТАХУУНЫ ЖИЖИГЛЭН
ХУДАЛДААНЫ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2018 оны 01 дүгээр
сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн зорилго нь шатахууны хил үнэнд валютын ханшын өөрчлөлтөөс нөлөөлөх нөлөөллийг бууруулах, шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах, газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлэх үндсэн зорилготой байсан.

Хууль эрх зүйн зохицуулалт:

Төв банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Өрсөлдөөний тухай хуулийн 13.3 дугаар заалт, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайд нар 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-171/46 дугаар хамтарсан тушаал гаргаж, “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах SIFS” дэд хөтөлбөрийг баталсан.

- ❖ Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2013 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А-187/183 дугаар хамтарсан тушаалаар дээрх дэд хөтөлбөрт нэмэлт 4 өөрчлөлт оруулан баталсан.
- ❖ Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2014 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар дээрх дэд хөтөлбөрт дахин нэмэлт өөрчлөлт оруулан баталсан ба уг нэмэлт өөрчлөлтөөр “Санхүүжилтийн нийт дүн 167 тэрбум” гэснийг “Шатахууны жижиглэнгийн худалдааны 2 сарын дундаж хэрэгцээнээс ихгүй” гэж, хөтөлбөр дэх Уул уурхайн яамны чиг үүрэгт 4 нэмэлт заалт, Монголбанкны чиг үүрэгт 3 нэмэлт заалт оруулж, улмаар хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнд хэд хэдэн өөрчлөлт оруулсан байна.

Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилтийн хэмжээ:

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа нь 3 жил байсан бөгөөд санхүүжилтийн нийт дүн 167 тэрбум төгрөг байхаар анх шийдвэрлэсэн. Хөтөлбөр хэрэгжүүлэгч компаниудад жилийн хугацаатай санхүүжилт олгосон бол газрын тосны бүтээгдэхүүн импортлогч ихэнх компаниудтай 2012 оны 11 дүгээр сард гэрээ байгуулан 3.8 хувийн хүүтэй зээлийг олгосон.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 222.8 тэрбум төгрөгийн зээлийг олгож, хөтөлбөрийг 2015 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүртэл үргэлжлүүлэхээр төлөвлөж байсан боловч хэлцлийг 2015 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон хөнгөлөлтэй зээлийн төлбөрийг эргүүлэн төлүүлсэн.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замын талаар:

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга механизм нь санхүүжилтийн өртгийг багасгах, хил дээрх өртгийн валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулахад чиглэсэн Монголбанкнаас тогтоосон хүүгээр зээлийн шугам нээх, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашиглах замаар хэрэгжүүлнэ гэж төлөвлөсөн.

Хөтөлбөрт хамрагдсан талууд:

SIFS дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монголбанк, Уул уурхайн /хуучин нэрээр/ яам, тусгай зөвшөөрөл эзэмшигч жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд болон хэрэгжүүлэгч компанийн сонгосон дотоодын банкууд оролцсон.

Хэрэгжиж буй дэд хөтөлбөрт тусгай зөвшөөрөл эзэмшигч, шатахууны худалдаа эрхлэгч нэр бүхий 14 компани, 8 арилжааны банк оролцсон байна. Үүнд: НИК, Петровис, Магнай трейд, Шунхлай, Сод монгол, Жаст Ойл, Петрожамп, М-Ойл, Ойн бирж, Хөрс автосервис, Монсуль, Рысжан, Ундрага Увс, Синчи Ойл компаниуд болон арилжааны Худалдаа хөгжил, Голомт, ХААН, Хас, Чингэс хаан, Капитал, Улаанбаатар хотын болон Төрийн банкууд оролцсон.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд тавьсан үнэлгээний талаар:

- SIFS дэд хөтөлбөрийн үр дүн, зорилтот ажлуудын биелэлт, хэрэгжилтийн үнэлгээг Монгол банк болон Уул, уурхайн яамнаас хамтран 2013-2015 онуудад 7 удаа гаргаж дүгнэсэн /2013/1, 2013/2, 2013/3, 2013/4, 2014/01, 2014/04, 2015/01/.
- Монгол банкны Ерөнхийлөгч болон Уул, уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А-64/75 дугаар хамтарсан тушаалын дагуу Монгол банк, УУЯ, Газрын тосны газрын хамтарсан шалгалтыг мөн сарын 18-наас 05 дугаар сарын 30-ны хооронд хийж, шалгалтын дүнгийн талаар танилцуулга, материал гаргасан байна.
- Монгол банкны Ерөнхийлөгч болон Уул, уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-155/222 дугаар хамтарсан тушаалаар дэд хөтөлбөрийн хэгжилтийн хугацааг 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөр тасалбар болгон дуусгавар болгож, дэд хөтөлбөрийн үнэлгээг хавсралтаар баталсан байна.

Хөтөлбөрийн явц, үр дүнгийн талаар:

Хөтөлбөрийг эхлүүлэхдээ нэр бүхий 13 компанид 191.9 тэрбум төгрөгийн жилийн 3.8 хувийн хүүтэй зээлийн шугам нээсэн ба форвард хэлцлээр олгох валютын дүн нь 137.9 сая ам.доллар байв. Хөтөлбөр эхлэх үеийн форвард хэлцлийн ханш 1391.5 төгрөг орчим байсан. Дэд хөтөлбөрийг 2014 онд сунгахад санхүүжилтийн эх үүсвэрийг 222.8 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн.

Уул уурхайн яамнаас хөтөлбөрт заагдсан үүргийнхээ дагуу 2012 оны 11 дүгээр сард Засгийн газрын 134 дүгээр тогтоолоор жижиглэнгээр болон бөөнөөр худалдаалж буй шатахууны онцгой албан татварын хувь хэмжээг ялгавартайгаар ногдуулах болсон.

Гадаад хил үнийн өөрчлөлттэй уялдуулан дотоодын жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах зорилгоор 2013 оны Засгийн газрын 236, 406 дугаар тогтоолоор ОАТ-ын хувь хэмжээнд өөрчлөлт оруулж байсан. Улмаар дотоодын зах зээлд худалдаалагдаж байсан шатахууны жижиглэн болон бөөний үнэд гажуудал үүссэнийг засч залруулахаар 2014 оны Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор шатахууны жижиглэнгийн болон бөөний худалдаанд онцгой албан татварын хувь хэмжээг ялгавартайгаар ногдуулж байсныг өөрчилсөн.

Засгийн газраас хэрэгжүүлж буй гадаад нийлүүлэгч нартай “Нэг цонх”-ны бодлогоор харьцах зорилгыг хэрэгжүүлэхээр манай гол нийлүүлэгч ОХУ-ын Роснефть, БНХАУ-ын Чайна Ойл компаниудтай Уул уурхайн /хуучин нэрээр/ яам хэлцэл хийж, олон улсын газрын тосны биржийн үнэнд суурилсан аргачлалаар нийлүүлэх шатахууныхаа үнийг тодорхойлж байхаар тохиролцож чадсанаар, урьд нь санал болгодог байсан гадаад хил үнийг нэр төрлөөс хамааруулан тонн тутамд 180-370 ам.доллараар бууруулсан.

Олон улсын зах зээлд түүхий газрын тосны үнэ буурснаар шатахууны гадаад үнэ мөн буурсан таатай боломжийг ашиглан 2014 оны 8 дугаар сараас эхлэн үе шаттайгаар валютын форвард хэлцлийн ханшийг 1441, 1515, 1575, 1715, 1850, 1930 болгох замаар зах зээлийн ханшид ойртуулах арга хэмжээ авсан.

Мөн 2015 оны 1 сараас дэд хөтөлбөрийн санхүүжилтийн зээлийн хүү жилийн 3.8 хувь байсныг 17-18 хувь болгосон байна. Шатахуунд ногдуулдаг онцгой албан татварын хувь хэмжээ 0-30 мянга байсныг 252-265 мянган төгрөг болгож өөрчилсөн.

Хөтөлбөрийн сайн тал, гарсан үр дүн	Хөтөлбөрийн дутагдалтай талууд
<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийн үр дүнд шатахууны худалдаа эрхлэгч компаниуд нэг цонхны бодлогоор гадаад нийлүүлэгчтэй харьцдаг болсон. ➤ Валютын ханшийн өөрчлөлт, шатахууны хилийн үнийн өсөлтөөс шалтгаалан шатахууны жижиглэнгийн үнийн өсөлт үүсэхээс сэргийлж чадсан. Өөрөөр хэлбэл хөтөлбөр хэрэгжүүлсэн хугацаанд манай улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний дотоодын жижиглэнгийн үнийн савалгаа үүсээгүй, шатахууны үнэ тогтвортой байж, хэрэглэгчдийн талархлыг хүлээсэн. ➤ Шатахууны үнийн өсөлтийг далимдуулан бусад хэрэглээний бараа, үйлчилгээний хиймэл үнийн өсөлт үүсдэг тогтолцоог хааж, бусад салбаруудыг эдийн засгийн хувьд 	<ul style="list-style-type: none"> ➤ Зарим аж ахуйн нэгжүүдэд олгосон санхүүжилт жижиглэнгийн борлуулалтын хэмжээнээс хэт өндөр тогтоогдож байсан. ➤ Авсан валютыг дансандаа удаан хугацаагаар байршуулах, утга тодорхойгүй гүйлгээ хийсэн, зээл төлсөн. ➤ Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэн, бөөний борлуулалт, нөөц, импортын мэдээ зөрүүтэй байх, зөрүүтэй мэдээ ирүүлсэн. ➤ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн импортлогч тодорхой тооны компаниудад валютын хөнгөлөлттэй зээл олгосон нь Монгол Улсын тодорхой төсвийг удаан хугацаагаар төвлөрүүлснээс

<p>тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Имфляцид үзүүлэх шатахууны үнийн өсөлтийн дарамтыг бууруулсан. ➤ Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч, шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхи нэмэгдэж, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн. ➤ Шатахуун импортлогч компаниуд гадаад валют худалдан авах зах зээл хайх шаардлагагүй болж, төлбөр тооцоо сааталгүй хийгдэж газрын тосны бүтээгдэхүүн худалдан авалтын хэмжээ өссөн. ➤ Компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлснээр газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн хэмжээ нэмэгдэж, шатахууны сарын үлдэгдэл нөөцийг 38 мянган тонноос 90 ба түүнээс дээш мянган тоннд хүргэж, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэртэй байдлыг хангасан. ➤ Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд Засгийн газрын шийдвэр гаргуулан шатахууны гааль, онцгой албан татварын хэмжээг зохих түвшинд хүргэн тогтоож, валютын ханш болон шатахууны хилийн үнийн өөрчлөлтөөс хамгаалах бололцоог бүрдүүлсэн. Шатахуунд ногдох ОАТ-ын хувь хэмжээ өссөнөөр 2015 онд Улсын төсөвт 360 орчим тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. 	<p>төсөвт тодорхой хэмжээний хүндрэл үүссэн.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийн гол зорилго, зорилтыг ойлгоогүйгээс төрөөс зориудаар хувийн хэвшлийн цөөн тооны аж ахуйнуудыг санхүүжүүлж байна гэсэн ойлголт иргэдэд төрсөн. ➤ Монголбанкны валютын нөөц хомсдолтой үед нийлүүлэлтийг дангаар хангахад хүндрэлтэй байсан.
--	--

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ